



МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/193

Улаанбаатар хот

Аргачилсан зөвлөмж хүлээн авах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.17 дахь заалт, ЭБМЗ-ийн 2018 оны ХХ-05-01, ХХ-05-02, ХХ-2018-09-01, 2019 оны ХХ-05-01, ХХ-05-02, ХХ-05-03, ХХ-05-04, ХХ-05-05, ХХ-14-01 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд уран-тори, нүүрс, алт, төмөр, шороон орд, хайлуур жонш, зэс, газрын тосны хайгуулын ажилд хэрэглэх аргачилсан зөвлөмжийг хүлээн авч баталсугай.

2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх Аргачилсан зөвлөмжийг холбогдох журмын дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг төсөл боловсруулагч (Г.Ухнаа, Л.Мөнхтоогоо, Г.Жамсрандорж) нарт даалгасугай.

3. Аргачилсан зөвлөмжийг хэвлэн олшруулж нийтэд түгээх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т, Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Б.Мөнхтөр)-т даалгасугай.

САЙД



Д.СУМЪЯАБАЗАР



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН  
ЗӨВЛӨМЖ

2018 оны 05 сарын 17 өдөр

Дугаар ХХ-05-01

Улаанбаатар хот

Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж хэлэлцсэн тухай

Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмжийн төслийг УУХҮЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн, МУ-ын зөвлөх инженер, геологич Д.Алтанхуяг боловсруулсныг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, дараах **ЗӨВЛӨМЖ**-ийг гаргаж байна. Үүнд:

1. Аргачилсан зөвлөмж нь “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”, “Ашигт малтмалын тухай” хууль, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/20 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам”, Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”-ын 3.7-д “ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн зэрэглэл, ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалын онцлогт тулгуурлан гаргасан зааварт нийцүүлж болно” гэж тус тус заасантай нийцсэн байна.

2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 23 дугаар тушаалаар батлагдсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийн 4 дэх хэсэг буюу зөвлөлийн Салбар хуралдааны хэлэлцэх асуудлын 4.1.1.2-т “Геологийн судалгаа, ашигт малтмалын эрэл, хайгуулын ажлын арга, аргачлал, заавар, журмын төсөл болон ашигт малтмалын нөөцийн ангилал, түүнд тавигдах шаардлагыг хэлэлцэж зөвлөмж, дүгнэлт гаргах”-аар заасны дагуу аргачилсан зөвлөмжийн төслийг боловсруулжээ.

3. Хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмалын баялаг, ордын нөөцийг нийтэд нээлтэй тайлагнах Монгол Улсын заавар (MRC Code) батлагдан, улмаар “Монгол Улсын хатуу ашигт малтмалын нөөц, эрдсийн баялгийн ангилал”-ыг Олон Улсын ижил төрлийн стандарт, заавруудтай дүйцүүлэх ажил хийгдсэнээр цаашид Монгол Улсын голлох төрлийн ашигт малтмал тус бүрээр ашигт малтмалын хайгуулын ажлын аргачилсан зөвлөмж, нөөцийн ангиллын заавруудыг боловсруулах зайлшгүй шаардлага бий болсон.

Олон Улсын хэмжээнд тодорхой хатуу ашигт малтмалуудын нөөц тогтоохдоо CRIRSCO-ийн зааварт нийцсэн Канад Улс SIM “NI 43-101”, мөн нүүрсний баялаг/нөөц тайлагнах стандартчилсан систем “GSC Paper 88-21”, Газрын тос ба хийн үйл ажиллагааны нээлтийн SIM NI 51-101 стандарт, “COGEN” (Канадын газрын тос ба хийн үнэлгээний заавар), Австрали Улсын “ЖОРК” гэх зэрэг заавар, стандартуудыг баримтлан зах зээл, томоохон хөрөнгийн биржүүдэд хувьцаа гаргаж, хөрөнгө босгох ажиллагаа

амжилттай хэрэгжиж байна. ОХУ-ын Хатуу ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг хэрэглэх аргачилсан зөвлөмж (Методические рекомендации по применению Классификации запасов месторождений и прогнозных ресурсов твердых полезных, 2007) материалыг тухайн ашигт малтмалын төрөл тус бүрээр боловсруулан эрэл хайгуулын үйл ажиллагаандаа даган мөрдөн, хэрэгжүүлж байна.

3. Зах зээлд уул уурхайн бүтээгдэхүүн болон хувьцаа гаргах, хөрөнгө босгох үйл ажиллагаа идэвхэжсэн боловч Монгол Улсад тухайн ашигт малтмалын геологийн судалгаа, эрэл хайгуулын чиглэлээр мөрдөх журам, заавар, зөвлөмжгүй байгаатай уялдан олон улсын хэмжээнд нийцэхүйц, хүлээн зөвшөөрөгдсөн, ашигт малтмалын судалгааны арга аргачлал, нөөцийн ангиллыг шинжлэх ухааны үндэслэлтэй, улмаар уламжлалт туршлага бүхий суурин дээрээ үндэслэн боловсронгуй болгох замаар цаашид дэлхийд өрсөлдөх чадварыг бий болгохуйц аргачилсан заавар шаардлагатай.

4. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Геологийн бодлогын газар нь энэ чиглэлийн төсөл хэрэгжүүлэгчдийг бодлогын удирдамжаар ханган, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл анхааралдаа авч, Төслийн хариуцлагатай гүйцэтгэгчийг туршлага, мэргэшсэн мэргэжилтний нөөц бүхий судалгаа, шинжилгээний болон төрийн бус, аж ахуйн нэгж байгууллагууд Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журмыг баримталж хамтран зохион байгуулж хэрэгжүүлэх боломжтой.

*Төсөл боловсруулагчийн илтгэл, тайлбар, дүгнэлт, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн дараах Дүгнэлт-ийг гаргаж, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад уламжлахаар шийдвэрлэв. Үүнд:*

Нэг. Монгол орны геологийн судалгаа, уул уурхайн үйлдвэрлэл, эдийн засагт нэн чухал суурийг эзэлж байгаа Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмжийг ашигт малтмалын төрөл тус бүрээр, тэдгээрийн ач холбогдлыг харгалзан дэс дараалалтай боловсруулж хэрэгжүүлэх,

Хоёр. Аргачилсан зөвлөмж нь оршил, ашигласан материал, хавсралт бүхий ордын геологи, түүний эрэл ба хайгуулын аргачлал, нөөцийн ангилал гэх зэргийг иж бүрэн хамарсан дараах үндсэн бүлгүүдтэй байна. Үүнд:

- Ерөнхий ойлголтууд,
- Хайгуулын зорилгоор ордыг геологийн тогтцын нийлмэл байдлаар бүлэглэх нь,
- Ордын геологийн тогтоц, хүдрийн эрдэслэг бүрэлдэхүүний судалгаа,
- Хүдрийн технологийн шинж чанарын судалгаа,
- Ордын гидрогеологи, инженер геологи, геоэкологийн ба байгалийн бусад нөхцөлийн судалгаа,
- Ордын нөөцийн тооцоолол ба баялгийн үнэлгээ,
- Ордын судлагдсан байдал,
- Ордын нөөцийг дахин тооцоолж баталгаажуулах.

Гурав. Энэ төрлийн төслийг гүйцэтгэгчид нь ашигт малтмалын доорх төрөл тус бүрд 2-3 зохиогчтой буюу тухайн ашигт малтмалын ордын геологи, эрэл хайгуулын чиглэлийн МУ-ын Зөвлөх мэргэжилтэн ахалж, туршлага бүхий мэргэшсэн зэрэгтэй геологи, мөн мэргэшсэн залгамж үеийг оролцуулсан, салбарын эрдэмтэд, мэргэжлийн холбоод болон хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн

мэргэжилтнүүдийг өргөнөөр хамруулах, ашигт малтмалын төрөл тус бүрд богино (10-12 сарын дотор) хугацаатайгаар гүйцэтгэн, боловсруулах. Үүнд:

1	Алтны үндсэн орд	11	Элс, хайрга	21	Газрын тос
2	Зэс	12	Карбонат чулуулаг	22	Бал чулуу
3	Холимог металл	13	Лити, цези, тантал	23	Хром
4	Цагаан тугалга, вольфрам	14	Газрын ховор элемент, тантал, ниоби	24	Барилгын /дайрга, өнгөлгөөний/ чулуу
5	Шороон орд	15	Каолин	25	Шавар
6	Молибден	16	Мөнгө	26	Фосфат
7	Уран	17	Марганец	27	Бор
8	Төмөр	18	Давс, нуурын давс	28	Берилли
9	Хайлуур жонш	19	Үнэт, эрдэнийн чулуу	29	Барит
10	Нүүрс, шатдаг занар	20	Хөнгөн цагаан	30	Асбест г.м

Цахиурлаг чулуулаг, гипс-ангидрит, тальк-пирофиллит, магнезит-брусит, хүхэр, мөнгөн ус, сурьма, никель-кобальт, судлын кварц-болор, исландын жонш гэх зэргээр, цаашилбал “Ордыг иж бүрэн судлах, дагалдах ашигт малтмал, компонент”, “Ордын хайгуул, нөөцийн тооцоонд геофизикийн сорьцлолтыг хэрэглэх” зэргээр боловсруулах.

Дөрөв. Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмжийн даалгавар, тухайн төсөл бүр даалгаврын дагуу хийгдсэн эсэхийг нягтлан, засвар хийлгэн, зөвлөмж өгч, саналыг тусгуулах үүрэг бүхий редакцын зөвлөлийг байгуулж баталгаажуулах, хөндлөнгийн шинжээчээр тухай бүр дүгнэлт гаргуулах, эдгээртэй холбогдох зардлыг тухайн төслийн санхүүжилтэд тусган шийдвэрлэж байх,

Тав. “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг ашигт малтмалын төрлүүдээр боловсруулан хэрэгжүүлэх, ажлын уялдааг хангах үүднээс редакцын зөвлөл байгуулах, төслийн даалгавар боловсруулж, санхүүжүүлэгч, хэрэгжүүлэгч байгууллагад тухай бүр мэдэгдэж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад уламжлахаар тогтов.

ТАНИЛЦСАН:

ЭБМЗ-ИЙН ДАРГА

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭБМЗ-ИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ  
ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ  
А.ДЭЛГЭРСАЙХАН  
Б.ЦАЦРАЛ



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН  
ЗӨВЛӨМЖ

2018 оны 07 сарын 05 өдөр

Дугаар ХХ-2018-09-01

Улаанбаатар хот

“Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврыг нүүрсний хайгуулд хэрэглэх зөвлөмж” хэлэлцсэн тухай

“Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврыг нүүрсний хайгуулд хэрэглэх зөвлөмж”-ийг Монгол Улсын зөвлөх инженер, геологич Л.Мөнхтогоо, түүнд шинжээчээр томилогдсон Монгол Улсын зөвлөх инженер, геологич Д.Алтанхуяг, Монгол Улсын мэргэшсэн инженер, геологич Ө.Энхтөгс нарын дүгнэлтийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, дараах **ЗӨВЛӨМЖ**-ийг гаргаж байна. Үүнд:

1. Аргачилсан зөвлөмж нь “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”, “Ашигт малтмалын тухай” хууль, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/20 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам”, Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”-ын 3.7-д “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн зэрэглэл, ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалын онцлогт тулгуурлан гаргасан зааварт нийцүүлж болно” гэж тус тус заасантай нийцсэн байна.

2. Хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмалын баялаг, ордын нөөцийг нийтэд нээлттэй тайлагнах Монгол Улсын заавар (MRC Code) батлагдан Ашигт малтмалын нөөцийг тайлагнах Олон Улсын стандартын хороо (CRIRSCO-Committee for Mineral Reserves International Reporting Standards)-нд 2014 онд гишүүнээр элсэн улмаар “Монгол Улсын хатуу ашигт малтмалын нөөц, эрдсийн баялгийн ангилал”-ыг Олон Улсын ижил төрлийн стандарт, заавруудтай дүйцүүлэх ажил хийгдсэнээр цаашид Монгол Улсын голлох төрлийн ашигт малтмал тус бүрээр ашигт малтмалын хайгуулын ажлын аргачилсан зөвлөмж, нөөцийн ангиллын заавруудыг боловсруулах зайлшгүй шаардлага бий болсон.

Олон Улсын хэмжээнд тодорхой хатуу ашигт малтмалуудын нөөц тогтоохдоо CRIRSCO-ийн зааварт нийцсэн Канад Улс SIM “NI43-101”, мөн нүүрсний баялаг/нөөц тайлагнах стандартчилсан систем “GSC Paper 88-21”, Газрын тос, байгалийн хийн NI 51-101 буюу “Standards of Disclosure for Oil and Gas Activities”, “COGEN - Canadian Oil and Gas Evaluation Handbook”, Австрали Улс “ЖОПК” гэх зэрэг заавар, стандартуудыг баримтлан зах зээл, томоохон хөрөнгийн биржүүдэд хувьцаа гаргаж, хөрөнгө босгох ажиллагаа амжилттай хэрэгжиж байна. Оросын Холбооны Улсад “Методические рекомендации по применению Классификации запасов месторождений и прогнозных ресурсов твердых полезных ископаемых” (2007) материалыг тухайн ашигт малтмалын төрөл тус бүрд тохируулан эрэл хайгуулын үйл ажиллагаандаа даган мөрдөн, хэрэгжүүлж байна.

Зөвлөмж нь Олон Улсын хэмжээнд мөрддөг Ашигт малтмалын нөөцийн ангилал, мөрддөг шаардлагуудтай нийцэж байгаа гэж зохиогч нар үзсэн байна. Ялангуяа ОХУ нь манай улстай хил залгаа оршдогоороо нүүрсний ордуудын геологийн тогтоц нь адил төстэй, нүүрсний нөөцөөрөө дэлхийд дээгүүр багтдаг ба ордууд нь олон төрлийн нас, структурт үүссэн тул хайгуулын аргачлал, нөөцийн ангиллыг олон талаас нь нягталж хийгдсэнийг тооцоолон ОХУ-ын аргачилсан удирдамжийг түлхүү ашиглажээ. Монголын нүүрсний геологичид ЗХУ-ын үеэс нүүрсний нөөцийн ангиллын зааврыг мөрдөж байсан тул нүүрсний ихэнх нөөц энэ ангиллаар тогтоогдсоноос гадна Улсын Геологийн Санд байгаа нүүрсний хайгуулын ажлын бараг бүх тайланд хэрэглэсэн нэр томьёо энэ зааврын дагуу хийгдсэн байдаг.

Зах зээлд уул уурхайн бүтээгдэхүүн болон хувьцаа гаргах, хөрөнгө босгох үйл ажиллагаа идэвхжсэн боловч Монгол Улсад тухайн ашигт малтмалын геологийн судалгаа, эрэл хайгуулын чиглэлээр мөрдөх журам, заавар, зөвлөмжгүй байгаатай уялдан Олон Улсын хэмжээнд нийцэхүйц, хүлээн зөвшөөрөгдсөн, ашигт малтмалын судалгааны арга аргачлал, нөөцийн ангиллыг шинжлэх ухааны үндэслэлтэй, улмаар уламжлалт туршлага бүхий суурин дээрээ үндэслэн боловсронгуй болгох замаар цаашид дэлхийд өрсөлдөх чадварыг бий болгохуйц аргачилсан заавар шаардлагатай байгаа юм.

3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 23 дугаар тушаалаар батлагдсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийн 4 дэх хэсэг буюу зөвлөлийн Салбар хуралдааны хэлэлцэх асуудлын 4.1.1.2-г “Геологийн судалгаа, ашигт малтмалын эрэл, хайгуулын ажлын арга, аргачлал, заавар, журмын төсөл болон ашигт малтмалын нөөцийн ангилал, түүнд тавигдах шаардлагыг хэлэлцэж зөвлөмж, дүгнэлт гаргах”-аар заасны дагуу аргачилсан зөвлөмж боловсруулагджээ. Үүнд: ЭБМЗ-өөс өгсөн чиглэлийн дагуу

- Зөвлөмж боловсруулах хууль зүйн үндэслэл,
- Ерөнхий ойлголтууд ,
- Орд, хэсгүүдийг хайгуулын зорилгоор, геологийн тогтцоор нь бүлэглэх нь,
- Ордын нөөцийн тооцооны өгөгдлүүдийг бүрдүүлэх нь,
- Нүүрсний ордын гидрогеологи, инженер геологи, экологийн зэрэг байгалийн нөхцөлийн судалгаа,
- Нөөцийн тооцоо гэсэн үндсэн бүлгүүдийг тусгасан байна.

Мөн хавсралтаар цооногийн геофизикийн судалгааны өгөгдлүүдийг нүүрсний нөөцийн тооцоонд ашиглах нөхцөл бүлгийг оруулсан байна. Бүлгүүдэд:

Зөвлөмж боловсруулах хууль зүйн үндэслэл гэсэн 1-р бүлэгт нүүрсний нөөцийн ангилал боловсруулах зайлшгүй шаардлага байгааг Засаг төрөөс гаргасан хууль эрхийн актуудыг баримт болгон харуулжээ.

Ерөнхий ойлголтууд гэсэн 2-р бүлэгт нүүрс гэж чухам юуг хэлэх вэ гэхээс эхлээд нүүрсний үе, давхраас, түүний бүтэц найрлага, байрлалын элемент, тогтоц гэсэн нэр томьёонууд, чанарын үзүүлэлтүүдийн илэрхийллийг нэгэн стандартад оруулах гэсэн оролдлого хийжээ. Харин “ашигт малтмалын баялаг”, “ордын нөөц”, “геологийн нөөц”, “үйлдвэрлэлийн нөөц”, “багтай”, “бодитой”, боломжтой”, “батлагдсан”, “магадалсан” нөөцийн тодорхойлолтыг Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааварт тодорхой тусгасан тул энд давхардуулан авч үзээгүй байна.

Орд хэсгүүдийг хайгуулын зорилгоор геологийн тогтцоор нь бүлэглэх нь гэсэн 3-р бүлгийг “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”-ын Хатуу ашигт малтмалын ордын бүлэглэл гэсэн бүлэгт нийцүүлэн, нүүрсний ордуудын онцлогт тохируулсан байна.

Ордын нөөцийн тооцооны өгөгдлүүдийг бүрдүүлэх нь гэсэн 4-р бүлэгт нүүрсний ордын хайгуулыг хийхэд 1:2000-аас 1:10000-ны масштабтай топографийн зураг бэлдэхээс эхлээд геологийн зураг, зүсэлтүүд зохиох, нүүрсний чанарын судалгаа явуулах, хайгуулын шугам хооронд болон цооног хоорондын зай ямар байх, ордын онцлогт тохируулан цооног, уулын ажил байрлуулах, дээжлэлт хийх, дээжийг лабораторид илгээх, дээжийн судалгаа тэдгээрийг боловсруулах зэрэг нөөц бодоход шаардагдах бүх өгөгдлүүдийг бүрдүүлэх талаар аргачилсан зөвлөмжүүдийг өгсөн байна.

Нүүрсний ордын гидрогеологи, инженер геологи, экологийн зэрэг байгалийн нөхцөлийн судалгаа гэсэн 5-р бүлэгт Ордын гидрогеологийн шинжилгээгээр ордыг усжуулж болох үндсэн уст горизонтыг судлан, усжсан хэсэг болон бүсийг илрүүлж, усыг нь ашиглах болон уурхайгаас зайлуулах асуудлыг шийдвэрлэх, байгаль хамгаалах асуудлаар уурхайн төсөлд бүрэн дүүрэн зөвлөмж өгсөн байх шаардлагатайг анхааруулжээ.

Инженер-геологийн судалгаагаар нүүрс болон агуулж байгаа чулуулгийн физик-механикийн шинж чанар, ан цав, ордыг ашиглах үед гарч болох орчин үеийн гадаад ба дотоод геологийн процессын нөлөөлөл зэргийг судалсан байх ёстой. Агуулагч чулуулгийн дээжлэлтийн нягт чулуулгийн өөрчлөлтийн зэргээс хамаарах ба нүүрсний давхраасын дээжлэлтийн нягтаас бага байж болохыг, олон жилийн цэвдэгтэй дүүрэгт чулуулгийн температурын горим, цэвдэгт хөрсний дээд, доод хил, хязгаар, гэсэх, хөлдөх үеийн чулуулгийн физик, механикийн шинж чанар, улирлын чанартай гэсэлт хөлдөлтийн гүн зэргийг тогтоох шаардлагатайг, инженер-геологийн судалгааны үр дүнд дээврийн чулуулгийн нурах буюу бэх бат чанар, уулын далд малталтын ул чулуулгийн бөх бат, овойлт, нүүрсний мөрөгцөгийн бөх бат чанарын талаар материал бэлтгэсэн байх ёстойг, хайгуулын талбайд ойр ажиллаж байгаа, гидрогеологи, инженер геологийн нөхцөлөөрөө ижил төстэй ил, далд уурхай байгаа тохиолдолд эдгээр ил, далд уурхайн усжилтын зэрэг, инженер геологийн нөхцөлийн талаарх өгөгдлүүдийг хуурайшуулах арга хэмжээ, уурхай нээх ажиллагаанд гарч болох хүндрэлүүдийг урьдчилан сэргийлэх ажиллагаанд ашиглах хэрэгтэйг анхааруулсан байна.

Экологийн судалгаагаар радиацийн түвшин, гадаргын ба газар доорх усны чанар, агаар, хөрс, ургамал, амьтны аймаг зэрэг хүрээлэн байгаа орчны ердийн байгаа байдлыг тогтоож, нутаг дэвсгэрийн тоосжилт, тэсэлгээнээс үүсэх чичирхийллийн үйлчлэл, гадаргын болон газар доорх усны бохирдол зэрэг уурхайн ажиллагаанаас үүсэж болох сөрөг нөлөөллийг урьдчилан тогтоосноор хэвийн байлгах арга хэмжээний талаар зөвлөжээ.

Нөөцийн тооцоо гэсэн 6-р бүлэгт нүүрсний ордын нөөцийн ангиллыг одоо мөрдөж байгаа, 2015 онд батлагдсан Зааврын 3.2-р зүйл, баялгийн ангиллыг мөн Зааврын 3.3. дагалдах бүрдвэрийн нөөцийг Зааврын 3.4-р зүйлд дурьдсан нөхцөлийг баримтлан хийхээр оруулжээ.

4. Цаашид тэмдэглэхэд “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврыг нүүрсний хайгуулд хэрэглэх” энэ зөвлөмжөөр нүүрсний хайгуулын бүх асуудлыг шийдвэрлэх боломжгүй. Тухайлбал нүүрсэнд байгаа хортой хольц, цацраг идэвхт бодисыг ямар хэмжээнд судалсан байвал зохихыг улсын хэмжээний судалгаа явуулж байж шийдвэрлэх шаардлагатай., шатдаг занар нүүрсний ордын дайвар бүтээгдэхүүн, метан хий дагавар бүтээгдэхүүн болох тохиолдол элбэг байгаа боловч хайгуулын ажил нь Газрын тосны тухай хуулиар зохицуулагддаг тул Ашигт малтмалын тухай хуулиар нүүрс хайхын тул газрын тосны хайгуулын зөвшөөрөл давхар авах эсвэл метан хий болон шатдаг занарыг нь судлахгүй орхих зөрчил үүсдэг зэрэг болно.

Эдгээр асуудлуудыг зохиогч дагалдан гарах заавруудаар зохицуулах санал дэвшүүлсэн байна. Үүнд:

- Нүүрсний уурхайн барилга байгууламжийг шинээр барих, шинэчлэх төсөлд зориулан геологи хайгуулын ажил явуулах, геологийн өгөгдөл материалаар хангах заавар;
- Нүүрсний хайгуулын явцад хортой хольц (цацраг идэвхт бодис, хүхэр, хүнцэл зэрэг) судлах заавар;
- Ордын иж бүрэн судалгаа ба дагалдах болон дайвар ашигт малтмалын нөөц бодох заавар;
- Хатуу ашигт малтмалын хайгуул болон ашиглалтад харьцуулалт хийх заавар.

Иймээс цаашид “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврыг нүүрсний хайгуулд хэрэглэх” зөвлөмжийг тухай бүр засварлаж сайжруулан дагаж мөрдөх шаардлагатай болохыг тэмдэглэв.

*Аргачилсан зөвлөмж боловсруулагчийн илтгэл, тайлбар, шинжээчдийн дүгнэлт, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн дараах Зөвлөмж-ийг гаргаж байна. Үүнд:*

Нэг. “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврыг нүүрсний хайгуулд хэрэглэх зөвлөмж”-ийг хүлээн авах,

Хоёр. Монгол Улсын нутаг дэвсгэрт нүүрсний хайгуул хийж байгаа хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид, байгууллагыг “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврыг нүүрсний хайгуулд хэрэглэх зөвлөмж”-ийг мөрдөн ажиллахыг зөвлөх,

Гурав. Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.17 дугаар заалтыг үндэслэн гарсан “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврын 3.7-д “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн зэрэглэл, ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалын онцлогт тулгуурлан гаргасан зааварт нийцүүлж болно” гэсний дагуу, “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврыг нүүрсний хайгуулд хэрэглэх зөвлөмж”-ийг боловсруулагч, мөн шинжээчдийн зардлыг эцэслэн, холбогдох шийдвэр гаргах боломжтойг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад уламжлахаар тогтов.

ТАНИЛЦСАН:

ЭБМЗ-ИЙН ДАРГА

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭБМЗ-ИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ  
ДАРГА

А.ДЭЛГЭРСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ЦАЦРАЛ





УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН  
ЗӨВЛӨМЖ

2018 оны 05 сарын 17 өдөр

Дугаар ХХ-05-02

Улаанбаатар хот

“Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврыг цацраг идэвхт ашигт малтмал (уран, тори)-ын ордын хайгуулд хэрэглэх аргачилсан зөвлөмж” хэлэлцсэн тухай

“Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврыг цацраг идэвхт ашигт малтмал (уран, тори)-ын ордын хайгуулд хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг Монгол Улсын зөвлөх инженер, геологич Г.Ухнаа, Д.Жамсрандорж, Г.Дэжидмаа, Д.Алтанхуяг, Монгол Улсын мэргэшсэн инженер, геологич Б.Мөнхтөр, геологич Ү.Ганбаатар, М.Буянзаяа, түүнд шинжээчээр томилогдсон Монгол Улсын мэргэшсэн инженер, геологич Б.Бат-Эрдэнэ, Б.Мөнхбаатар нарын дүгнэлтийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, дараах **ЗӨВЛӨМЖ**-ийг гаргаж байна. Үүнд:

1. Аргачилсан зөвлөмж нь “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”, “Ашигт малтмалын тухай” хууль, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/20 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам”, Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”-ын 3.7-д “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн зэрэглэл, ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалын онцлогт тулгуурлан гаргасан зааварт нийцүүлж болно” гэж тус тус заасантай нийцсэн байна.

2. Хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмалын баялаг, ордын нөөцийг нийтэд нээлттэй тайлагнах Монгол Улсын заавар (MRC Code) батлагдан, улмаар “Монгол Улсын хатуу ашигт малтмалын нөөц, эрдсийн баялгийн ангилал”-ыг Олон Улсын ижил төрлийн стандарт, заавруудтай дүйцүүлэх ажил хийгдсэнээр цаашид Монгол Улсын голлох төрлийн ашигт малтмал тус бүрээр ашигт малтмалын хайгуулын ажлын аргачилсан зөвлөмж, нөөцийн ангиллын заавруудыг боловсруулах зайлшгүй шаардлага бий болсон.

Олон Улсын хэмжээнд тодорхой хатуу ашигт малтмалуудын нөөц тогтоохдоо CRIRSCO-ийн зааварт нийцсэн Канад Улс SIM “NI43-101”, Австрали Улс “ЖОПК” гэх зэрэг заавар, стандартуудыг баримтлан зах зээл, томоохон хөрөнгийн биржүүдэд хувьцаа гаргаж, хөрөнгө босгох ажиллагаа амжилттай хэрэгжиж байна. Оросын Холбооны Улсад “Методические рекомендации по применению Классификации запасов месторождений и прогнозных ресурсов твердых полезных ископаемых” (2007) материалыг тухайн ашигт малтмалын төрөл тус бүрд тохируулан эрэл хайгуулын үйл ажиллагаандаа даган мөрдөн, хэрэгжүүлж байна.

Зөвлөмж нь Олон Улсын хэмжээнд мөрддөг Ашигт малтмалын нөөцийн ангилал, мөрддөг шаардлагуудтай нийцэж байгаа гэж зохиогч нар үзсэн байна. Олон Улсын

Атомын Энергийн Агентлагаас ураны ордуудын ангиллыг гаргаж олон улсад мөрдүүлж байгаа болон манай орны ураны ордуудын хайгуулд ЗХУ /хуучнаар/, Канад, Франц гэх зэрэг орны компаниуд өөрсдийн арга, аргачлалаар хайгуул хийж байсан. Монгол орны ураны ордуудын геологийн тогтоц нь олон төрлийн геодинамикийн нөхцөл байдалд үүссэн тул хайгуулын аргачлал, нөөцийн ангиллыг олон улсын туршлагад тулгуурлан нягталж илүү тодорхой аргачилсан зөвлөмжөөр эрх зүйн хувьд хуульчилсныг үндэслэн ОХУ-ын аргачилсан удирдамжийг гол үндэс болгон авчээ. Монголд ЗХУ-ын үеэс ураны нөөцийн ангиллын зааврыг мөрдөж байсан тул ураны багагүй нөөц энэ ангиллаар бүртгэгдсэнээс гадна Улсын Геологийн Мэдээллийн Санд байгаа ураны хайгуулын ажлын ихэнх тайланд хэрэглэсэн нэр томьёо энэ зааврын дагуу хийгдсэн байдаг.

Зах зээлд уул уурхайн бүтээгдэхүүн болон хувьцаа гаргах, хөрөнгө босгох үйл ажиллагаа идэвхижсэн боловч Монгол Улсад тухайн ашигт малтмалын геологийн судалгаа, эрэл хайгуулын чиглэлээр мөрдөх журам, заавар, зөвлөмжгүй байгаатай уялдан Олон Улсын хэмжээнд нийцэхүйц, хүлээн зөвшөөрөгдсөн, ашигт малтмалын судалгааны арга аргачлал, нөөцийн ангиллыг шинжлэх ухааны үндэслэлтэй, улмаар уламжлалт туршлага бүхий суурин дээрээ үндэслэн боловсронгуй болгох замаар цаашид дэлхийд өрсөлдөх чадварыг бий болгохуйц аргачилсан заавар шаардлага бий болсон.

3. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 23 дугаар тушаалаар батлагдсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийн 4 дэх хэсэг буюу зөвлөлийн Салбар хуралдааны хэлэлцэх асуудлын 4.1.1.2-т “Геологийн судалгаа, ашигт малтмалын эрэл, хайгуулын ажлын арга, аргачлал, заавар, журмын төсөл болон ашигт малтмалын нөөцийн ангилал, түүнд тавигдах шаардлагыг хэлэлцэж зөвлөмж, дүгнэлт гаргах”-аар заасны дагуу аргачилсан зөвлөмж боловсруулагджээ. Үүнд:

- Ерөнхий зүйл,
- Уран ба бусад хамт тохиолдох элементүүд, тэдгээрийн байгаль дээрх орших нь,
- Ураны ордуудын ангилал,
- Тори агуулагч ордуудын ангилал,
- Хайгуулын зорилгоор ураны ордуудыг геологийн тогтцын нийлмэл байдлаар бүлэглэх нь,
- Ордын геологийн тогтоц, хүдрийн эрдэслэг бүрэлдэхүүний судалгаа,
- Хүдрийн технологийн шинж чанарын судалгаа,
- Ордын гидрогеологи, инженер геологи, геоэкологийн ба байгалийн бусад нөхцөлийн судалгаа,
- Нөөцийн тооцоолол,
- Ордын судлагдсан байдал,
- Ордын нөөцийг дахин тооцоолж баталгаажуулах.

Хавсралтаар хатуу ашигт малтмалын ордуудын геологийн тогтцын нийлмэл байдлыг тогтооход ашигладаг үзүүлэлтүүд, ураны хүдрийг малталтын аргаар олборлох, боловсруулах ерөнхий бүдүүвч, ураны хүдрийг газрын доор уусган баяжуулж олборлох ерөнхий бүдүүвч, зөвлөмж дэх товчилсон үгнүүд болон зарим нэр томьёоны тайлбар, зөвлөмжид тусгагдсан ба монгол хэлээр бичихэд маргаантай байдаг зарим үг, нэр томьёоны монгол, орос, англи толь зэргийг оруулсан байна. Бүлгүүдэд:

Ерөнхий зүйл гэсэн эхний хэсэгт цацраг идэвхт ашигт малтмалын ордуудын нөөцийн ангилал боловсруулах зорилго, төр, засгаас гаргасан газар доор уусган олборлохтой холбоотой зарим хууль эрхийн актууд, олон улсын ангилал зэргийг нэр заажээ.

Уран ба бусад хамт тохиолдох элементүүд, тэдгээрийн байгаль дээрх орших нь гэсэн 1 дүгээр бүлэгт уран, радий, радон, тори зэрэг цацраг идэвхт элементүүдийн тодорхойлолтыг өгч, байгаль дээр тохиолддог эрдсүүдийг найрлагын хамт хүснэгтээр харуулсан байна.

Ураны ордуудын ангилал гэсэн 2 дугаар бүлэгт Олон Улсын атомын энергийн агентлагийн 2013 оны “Ураны ордууд, нөөцийн ангилал”-ын дагуу ураны ордуудыг 15 бүлэгт хуваан авч үзэж гадаадын томоохон сонгодог ордууд болон Монгол орны ураны ордуудыг аль бүлэгт хамрагддаг талаар өгүүлжээ.

Тори агуулагч ордуудыг ангилах нь гэсэн 3 дугаар бүлэгт тори дангаараа үйлдвэрлэлийн ач холбогдолтой ордууд үүсгэдэггүй бөгөөд харин өөр төрлийн ашигт малтмалуудтай хамт нийлмэл найрлагатай үндсэн болон шороон ордуудад хуримтлагдсан байдаг гээд тори агуулагч ордуудыг хүснэгтээр үзүүлсэн байна.

Хайгуулын зорилгоор ураны ордуудыг геологийн тогтцын нийлмэл байдлаар нь бүлэглэх нь гэсэн 4 дүгээр бүлгийг “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”-ын Хатуу ашигт малтмалын ордын бүлэглэл гэсэн бүлэгт нийцүүлэн ураны ордуудын хүдрийн биетийн хэлбэр, хэмжээ, зузааны өөрчлөмтгий байдал, дотоод бүтцийн нийлмэл байдал, ураны тархалтын онцлог зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан 2, 3, 4 дүгээр бүлэгт хамааруулж үзэхээр тусгасан байна.

Ордын геологийн тогтоц, хүдрийн эрдэслэг бүрэлдэхүүний судалгаа гэсэн 5 дугаар бүлэгт ураны ордуудын хайгуулын үед хүдрийн биетийг судлах болон хайгуулын торын нягтрал, сорьцлолтын үндсэн нөхцөл, лабораторийн шинжилгээ зэрэгт тавих шаардлагуудыг тусгажээ.

Хүдрийн технологийн шинж чанарын судалгаа гэсэн 6 дугаар бүлэгт ураны хүдрийг олборлоход тавих технологийн үндсэн шаардлагад хэрхэн нийцүүлэх судлах үндсэн зарчмуудыг тусгасан байна.

Ордын гидрогеологи, инженер геологи, геоэкологийн ба байгалийн бусад нөхцөлийн судалгаа гэсэн 7 дугаар бүлэгт Ордын гидрогеологийн шинжилгээгээр уст горизонтыг судлан, усжсан хэсэг болон бүсийг илрүүлж, усыг нь ашиглах болон уурхайгаас шавхах, түүнээс үүдэх асуудлыг шийдвэрлэх, газрын доор уусган олборлоход ордын гидрогеологийн бүх нөхцөлийг судлах, түүнтэй холбоотой байгаль хамгаалах асуудлаар уурхайн төсөлд бүрэн дүүрэн зөвлөмж өгсөн байх шаардлагатайг анхааруулжээ. Мөн инженер геологийн болон экологийн судалгаагаар хийгдэх шаардлагатай ажлууд, шийдвэрлэсэн байх асуудлуудын талаар болон экологийн судалгаанд онцгой анхаарал хандуулах шаардлагатай болохыг дурджээ.

Нөөцийн тооцоолол гэсэн 8 дугаар бүлэгт ураны ордын нөөцийн ангиллыг одоо мөрдөж байгаа, 2015 онд батлагдсан Зааврын 3.2 дугаар зүйл, баялгийн ангиллыг мөн Зааврын 3.3, дагалдах бүрдвэрийн нөөцийг Зааврын 3.4 дугаар зүйлд дурдсан нөхцөлийг баримтлан нөөцийг хэрхэн ангилах талаар оруулжээ.

Ордын судлагдсан байдал гэсэн 9 дүгээр бүлэгт хайгуул хийгдсэн ордын нөөцийг олборлоход шаардлагатай доорх мэдээллүүдийг бүрэн дүүрэн тусгасан байна. Үүнд: хүдрийн технологийн төрөл ба сортуудыг ялгаж, үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий ашигт бүрдвэрүүдийг иж бүрдлээр гарган авах, боловсруулах үйлдвэрлэлийн технологийн оновчтой горимыг сонгож болохуйц мэдээллийг бүрэлдүүлсэн байх, үйлдвэрлэлийн хаягдлыг ашиглах чиглэлийг тогтоох, газрын доор уусгах аргаар олборлох ордын хувьд

газар доор уусгах үйлдвэрлэлийн технологийн туршилтыг уусмалаас эцсийн бүтээгдэхүүн гарган авах хүртэл бүтэн схем гаргах, дагалдах ашигт бүрдвэрүүд, хөрс хуулалтаас гарсан бүтээгдэхүүний нөөц, хэрэглэх чиглэлийг тогтоох, гидрогеологи, инженер геологи, уул техникийн болон бусад байгалийн нөхцөлүүд нь байгаль хамгааллын, үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны шаардлагуудыг харгалзсан олборлох, боловсруулах үйлдвэрийн төсөл боловсруулахад бүх шаардлагатай мэдээлэл бүрдүүлэх талаар дурджээ.

Ордын нөөцийг дахин тооцоолж баталгаажуулах гэсэн 10 дугаар бүлэгт ордын нөөцийг ямар нөхцөлд дахин тооцоолж баталгаажуулах нөхцөлүүд, шаардлагыг дурджээ.

“Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврыг цацраг идэвхт ашигт малтмал (уран, тори)-ын ордын хайгуулд хэрэглэх аргачилсан зөвлөмж” нь цаашид цаг үеийн шаардлага, цацраг идэвхт ашигт малтмалын судалгаа, ажлын арга, аргачлал, олборлох технологи, нэр томъёоны асуудал, хууль эрх зүйн орчин гэх зэргээс шалтгаанаар тухай бүр өөрчлөлт, засвар, шинэчлэл хийж байхыг тэмдэглэв.

*Аргачилсан зөвлөмж боловсруулагчийн илтгэл, тайлбар, шинжээчдийн дүгнэлт, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн дараах Зөвлөмж-ийг гаргаж байна. Үүнд:*

Нэг “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврыг цацраг идэвхт ашигт малтмалын ордын хайгуулд хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг хүлээн авах,

Хоёр. Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.17 дугаар заалтыг үндэслэн гарсан “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврын 3.7-д “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн зэрэглэл, ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалын онцлогт тулгуурлан гаргасан зааварт нийцүүлж болно” гэсний дагуу, энэхүү Аргачилсан зөвлөмжид, мөн шинжээчдийн зардлыг эцэслэн, холбогдох шийдвэр гаргах боломжтойг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад уламжлах,

Гурав. “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврыг цацраг идэвхт ашигт малтмалын ордын хайгуулд хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг Монгол Улсын нутаг дэвсгэрт ураны ордын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудад мөрдөн ажиллахыг зөвлөх.

ТАНИЛЦСАН:

ЭБМЗ-ИЙН ДАРГА

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭБМЗ-ИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ  
ДАРГА

А.ДЭЛГЭРСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.ЦАЦРАЛ



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН  
ЗӨВЛӨМЖ

2015 оны 04 сарын 05 өдөр

Дугаар 22-05-04

Улаанбаатар хот

“Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (алтны үндсэн орд) хэрэглэх аргачилсан зөвлөмж” хэлэлцсэн тухай

“Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (алтны үндсэн орд) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг Монгол Улсын зөвлөх инженер, геологич доктор /Ph.D/, Г.Дэжидмаа, Монгол Улсын зөвлөх инженер, геологич, доктор /Ph.D/, профессор С.Жаргалан, Монгол Улсын мэргэшсэн геологич О.Ганцэцэг нар боловсруулж, түүнд шинжээчээр геологич Ц.Баярсайхан, Монгол Улсын зөвлөх инженер, баяжуулагч, доктор /Ph.D/, дэд профессор С.Оюунцэцэг, Монгол Улсын зөвлөх инженер, баяжуулагч, доктор /Ph.D/, дэд профессор Н.Буянхишиг нар ажиллан дүгнэлт гаргасныг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд дараах **ЗӨВЛӨМЖ**-ийг гаргаж байна. Үүнд:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/46 тоот тушаалаар батлагдсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийн 4 дэх хэсэг буюу зөвлөлийн Салбар хуралдааны хэлэлцэх асуудлын 4.1.2.3-т “Ашигт малтмалын эрэл, хайгуулын ажлын арга, аргачлал, заавар, журмын төсөл болон ашигт малтмалын нөөцийн ангилал, түүнд тавигдах шаардлага, гарын авлага, зөвлөмж”-ийг хэлэлцэж зөвлөмж, дүгнэлт гаргах гэж заасны дагуу “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (алтны үндсэн орд) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаар хэлэлцсэн.

Аргачилсан зөвлөмж нь дараах үндсэн бүлгүүдээс бүрджээ. Үүнд:

- Ерөнхий ойлголт
- Хайгуул хийх зорилгоор ордыг геологийн тогтоцын нийлмэл байдлаар бүлэглэх нь
- Ордын геологийн ба хүдрийн бодисын найрлагын судалгаа
- Хүдрийн технологийн шинж чанарын судалгаа
- Ордын гидрогеологи, инженер геологи, геоэкологийн ба байгалийн бусад нөхцлийн судалгаа
- Нөөцийн тооцоолол
- Ордын (түүний хэсгүүдийн) судалгааны түвшин
- Нөөцийн дахин тооцоолол ба дахин бүртгэлт

Мөн хавсралтаар цианид бодисууд хэрэглэдэг нуруулдан уусгах технологийн зарчмын бүдүүвч, Бороогийн алт-сульфид-кварцын ордын хүдрийг боловсруулсан технологийн бүдүүвч, Бороогийн ордын бага агуулгатай хүдрийг нуруулдан уусгасан технологийн бүдүүвч, Гацууртын ордын исэлдсэн хүдрийг боловсруулах технологийн бүдүүвч, Гацууртын ордын алт-сульфид-кварц, алт-сульфидын анхдагч хүдрийг боловсруулах технологийн бүдүүвчийг тус тус оруулсан байна.

2. Аргачилсан зөвлөмж нь “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”, “Ашигт малтмалын тухай” хууль, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/20 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам”, Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалаар баталсан “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”-ын 3.7-д “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн зэрэглэл, ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалын онцлогт тулгуурлан гаргасан зааварт нийцүүлж болно” гэж тус тус заасантай нийцжээ.

3. Хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмалын баялаг, ордын нөөцийг нийтэд нээлттэй тайлагнах Монгол Улсын заавар (MRC Code) батлагдан, Ашигт малтмалын нөөцийг тайлагнах Олон Улсын стандартын хороо (CRIRSCO-Committee for Mineral Reserves International Reporting Standards)-нд 2014 онд гишүүнээр элсэж улмаар “Монгол Улсын хатуу ашигт малтмалын нөөц, эрдсийн баялгийн ангилал”-ыг Олон Улсын ижил төрлийн стандарт, заавруудтай дүйцүүлэх ажил хийгдсэнээр цаашид Монгол Улсад ашигт малтмалын хайгуулын ажлын аргачилсан зөвлөмж, нөөцийн ангиллын заавруудыг боловсруулах зайлшгүй шаардлага бий болсон байна.

Мөн олон улсын хэмжээнд тодорхой хатуу ашигт малтмалуудын нөөцийг тайлагнахад CRIRSCO-ийн зааварт нийцсэн Канад улс SIM “NI43-101”, Австрали улс “ЖОРК” гэх зэрэг заавар, стандартуудыг баримтлан зах зээл, томоохон хөрөнгийн биржүүдэд хувьцаа гаргаж, хөрөнгө босгох ажиллагаа амжилттай хэрэгжиж байна. Оросын Холбооны Улсад “Методические рекомендации по применению Классификации запасов месторождений и прогнозных ресурсов твердых полезных ископаемых” (2007) материалыг тухайн ашигт малтмалын төрөл тус бүрд тохируулан эрэл хайгуулын үйл ажиллагаандаа даган мөрдөн, хэрэгжүүлж байна.

Аргачилсан зөвлөмж нь олон улсын хэмжээнд мөрддөг Ашигт малтмалын нөөцийн ангилал, шаардлагуудтай нийцэж байгаа гэж зохиогч нар үзсэн байна. Ялангуяа ОХУ нь манай улстай хил залгаа оршдоогоороо ордуудын геологийн тогтоц нь адил төстэй, нөөцөөрөө дэлхийд дээгүүр багтдаг ба ордууд нь олон төрлийн нас, структурт үүссэн тул хайгуулын аргачлал, нөөцийн ангиллыг олон талаас нь нягталж хийгдсэнийг тооцоолон ОХУ-ын аргачилсан удирдамжийг түлхүү ашиглажээ. Ер нь Монголын геологичид ЗХУ-ын үеэс нөөцийн ангиллын зааврыг мөрдөж байсан тул ордын ихэнх нөөц энэ ангиллаар тогтоогдсоноос гадна Улсын геологийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа хайгуулын ажлын бараг бүх тайланд хэрэглэсэн нэр томьёо энэ зааврын дагуу хийгдсэн байдаг.

4. ЭБМЗ-ийн хуралдааны үед “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (алтны үндсэн орд) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-д нөөцийн зэрэг гэснийг зэрэглэл болгох зэргээр зарим ижил нэр томьёог бусад аргачилсан зөвлөмжид өөр өөрөөр тусгагдсан байгааг анхаарч нэг мөр болгох, мөн бүлгийн нэрийг ижил болгох, хэт бага буюу ядуу агуулгатай хүдрийг нэмж тусгах зэрэг асуудлыг зөвлөлийн гишүүдийн олонхын саналыг үндэслэн аргачилсан зөвлөмжид тусгахаар шийдвэрлэсэн.

5. Зах зээлд уул уурхайн бүтээгдэхүүн болон хувьцаа гаргах, хөрөнгө босгох үйл ажиллагаа идэвхжсэн боловч Монгол Улсад тухайн ашигт малтмалын геологийн судалгаа, эрэл хайгуулын чиглэлээр мөрдөх журам, заавар, зөвлөмжгүй байгаатай уялдан Олон Улсын хэмжээнд нийцэхүйц, хүлээн зөвшөөрөгдсөн, ашигт малтмалын судалгааны арга аргачлал, нөөцийн ангиллыг шинжлэх ухааны үндэслэлтэй, улмаар уламжлалт туршлага бүхий суурин дээрээ үндэслэн боловсронгуй болгох замаар цаашид дэлхийд өрсөлдөх чадварыг бий болгохуйц аргачилсан заавар шаардлагатай байх тул Монгол Улсын нутаг дэвсгэрт алтны үндсэн ордын хайгуул хийж байгаа хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид, байгууллагуудыг “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн

төрлийн ашигт малтмалд (алтны үндсэн орд) хэрэглэх аргачилсан зөвлөмж"-ийг мөрдөн ажиллах нь зүйтэй гэж үзэв.

*Аргачилсан зөвлөмж боловсруулагчийн илтгэл, тайлбар, шинжээчдийн дүгнэлт зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас гаргаж буй дараах зөвлөмжийг үндэслэн холбогдох шийдвэр гаргахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад уламжлахаар шийдвэрлэв.*


Нэг. “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (алтны үндсэн орд) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг хүлээн авах.

Хоёр. Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.17 дугаар заалтыг үндэслэн гарсан “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврын 3.7-д “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн зэрэглэл, ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалын онцлогт тулгуурлан гаргасан зааварт нийцүүлж болно” гэсний дагуу, “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (алтны үндсэн орд) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг хэрэгжүүлэх талаар холбогдох шийдвэр гаргах,

Гурав. “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааварт” суурилсан “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (алтны үндсэн орд) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг хэрэглэх үндэслэлтэй болох тул Монгол Улсын нутаг дэвсгэрт алтны үндсэн ордын хайгуул хийж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчидэд таниулан сурталчилахыг эрх бүхий байгууллагад чиглэл өгөх.

ТАНИЛЦСАН:

ЭБМЗ-ИЙН ДАРГА



Б.МӨНХТӨР

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭБМЗ-ИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ  
ДАРГА



А.ДЭЛГЭРСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.БАЯРСАЙХАН

ТУС № 0810



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН  
ЗӨВЛӨМЖ

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар ХХ-05-03

Улаанбаатар хот

*“Газрын тосны баялаг, ордын нөөцийн ангилал, зэрэглэлийг хэрэглэх аргачилсан зөвлөмж” хэлэлцсэн тухай*

Монгол Улсын “Газрын тосны баялаг, ордын нөөцийн ангилал, зэрэглэлийг хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг Монгол Улсын зөвлөх инженер, геологич Л.Алтангэрэл, доктор /PhD/ Д.Буян-Арвижих, доктор /PhD/, дэд профессор, зөвлөх инженер Д.Алтанхуяг нар боловсруулж, түүнд шинжээчээр Улсын зөвлөх геологич Д.Жанчив, доктор /Ph.D/, дэд профессор Н.Буянхишиг нар ажиллан гаргасан дүгнэлтийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд дараах **ЗӨВЛӨМЖ**-ийг гаргаж байна. Үүнд:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/46 тоот тушаалаар батлагдсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийн 4 дэх хэсэг буюу зөвлөлийн Салбар хуралдааны хэлэлцэх асуудлын 4.1.2.3-т “Ашигт малтмалын эрэл, хайгуулын ажлын арга, аргачлал, заавар, журмын төсөл болон ашигт малтмалын нөөцийн ангилал, түүнд тавигдах шаардлага, гарын авлага, зөвлөмж”-ийг хэлэлцэж зөвлөмж, дүгнэлт гаргах гэж заасны дагуу Монгол Улсын “Газрын тосны баялаг, ордын нөөцийн ангилал, зэрэглэлийг хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаар хэлэлцсэн.

Аргачилсан зөвлөмж нь дараах үндсэн бүлгүүдээс бүрджээ. Үүнд:  
Ерөнхий ойлголт:

- Үндсэн ойлголтууд
  - Үндсэн ба дагалдах ашигт бүрдвэр
  - Газрын тосны ордын геологийн тогтоц
- Газрын тосны баялгийн менежментийн систем:
- Үндсэн зарчмууд ба тодорхойлолтууд
    - Газрын тосны баялгийн ангилал
    - Баялгийн төсөлд суурилсан систем
  - Газрын тосны баялгийн ангилал ба нөөцийн зэрэглэл
    - Нөөцийн зэрэглэл
    - Тодорхойгүй байдлын хязгаар, түүний зэрэглэл
    - Нэмэлт төслүүд
    - Уламжлалт бус нөөц
  - Үнэлгээ болон тайлан
    - Эдийн засгийн ашигтай байх нөхцлийг үнэлэх
    - Бүтээгдэхүүнийг хэмжих
  - Ашиглах хэмжээг тооцоолох
    - Шинжилгээний процедур
    - Нөөцийг үнэлэх аргууд



Газрын тосны баялгийн менежментийн системийг хэрэглэх аргачилсан заавар:

-Газрын тосны баялаг, нөөцийн ангилал ба зэрэглэлд тавих шаардлага

-Нөөцийн тооцооллын арга

Нөөцийн тооцооны үндсэн нөхцөлүүд

Мөн хавсралтаар баялаг, нөөцийн үнэлгээнд хэрэглэгдэх нэр томъёоны тайлбар, зөвлөмж дэх товчилсон үгнүүдийн нэр томъёоны тайлбарыг тус тус оруулсан байна.

2. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 169 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар 2027 он хүртэл баримтлах бодлого”-ын зорилтын 2.3.1.4-т “салбарын үйл ажиллагааны стандарт, дүрэм, журмыг боловсронгуй болгох, шинээр боловсруулах, сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах”-аар заасан. Мөн Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т “газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага”, 9 дүгээр зүйлийн 9.1.19-д “газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах стандарт, дүрэм, журам, зааврыг боловсруулж батлуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих” тухай хуульчилсан байна. Түүнчлэн Уул уурхайн сайдын 2015 оны 49 дүгээр тушаалаар “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавигдах шаардлага” журмыг баталсан.

3. Монгол Улсын Эрдэс баялгийн нөөцийн нэгдсэн санд бүртгэгдээд байгаа Зүүнбаян, Цагаан элс, Тосон Уул, Тамсагийн газрын тосны ордуудын нийт 332.6 сая тн (түүнээс ашиглалтын 43.2 сая.тн) баталгаат нөөцийг Газрын тосны газрын даргын 2010 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 17 дугаар тушаалаар баталсан “Газрын тосны нөөцийн тайлангийн агуулга, түүнд тавигдах шаардлага”-ын дагуу хүлээн авсан байдаг. Энэхүү шаардлагад Газрын тос олборлогч ихэнх орнуудын дагаж мөрддөг Газрын тосны инженерүүдийн холбоо (SPE), Дэлхийн газрын тосны зөвлөл (WPC), АНУ-ын Газрын тосны геологийн ассоциаци (AAPG), Газрын тосны үнэлгээний инженерийн зөвлөл (SPEE)-өөр хүлээн зөвшөөрөгдсөн нөөцийн ангилалын дагуу газрын тосны нөөц, тосонд ууссан хийн нөөцийг баталгаат (proved), магадтай (probable), боломжит (possible) зэрэглэлээр тооцоолсон байхаар журамласан байдаг байна.

Газрын тос, хийн ангилал, тодорхойлолтууд нь Олон улсын Техникийн стандарт (UNFC, SPE), Хөрөнгийн биржийн журам (SEC, Canadian (CSA), UK SORP), Үндэсний хэмжээнд тайлагнах баримт (Norway-NPD, Russian Federation-GKZ, China-PRO, АНУ-USGS) хэлбэрээр боловсруулагдсан байдаг. Тодруулбал өнөөдөр Олон улсын хэмжээнд НҮБ-ын UNFC-2009 (The United Nations Framework Classification for Fossil Energy and Mineral Reserves and Resources)-с гадна Газрын тосны инженерүүдийн нийгэмлэг (SPE)-ийн дэргэдэх Газрын тос, Хийн Нөөцийн Комисс-ГХНК (Oil and Gas Reserve Committee-OGRC\*)-оос боловсруулсан Газрын тосны баялгийн менежментийн систем (Petroleum Resources Management System, PRMS-2018)-ийг тухайн онд шинэчлэн хэрэглэж байна. ГХНК (OGRC) нь техникийн баримт бичиг болох:

-SPE, WPC, AAPG, SPEE, SEG, SPWLA, EAGE зэрэг байгууллагуудын дэмжлэгтэйгээр 2018 онд ГБМС (PRMS),

- PRMS-ийг хэрэглэх заавар (“Guidelines” for Application of the Petroleum Resources Management System), 2011. Заавар нь баялаг, нөөцийн тооцооллын зарчмын хэрэглээнд өргөн хүрээний мэдээллийн эх үүсвэрийг ашиглан AAPG, SEG, SPEE, WPC ийн хамтын ажиллагааны үр дүнд боловсруулсан,

-Газрын тос, хийн нөөцийн мэдээллийн аудит ба тооцоололд хамаарах стандартууд. 2007. (“Auditing Standards”),

-Зарим нөөц, баялгийн ангилалуудын харьцуулалт ба холбогдох тодорхойлолтууд. 2005 (“Mapping Report”) зэргийг тус тус эцэслэн нийтэд нээлттэй болгожээ.

НҮБ (UNFC-2009) жил тутам, ОХУ (Классификация запасов и ресурсов нефти и горючих газов-2013) 2016 онд баталгаажуулсан, Канад (CSA) NI51-101 буюу “Standards of

Disclosure for Oil and Gas Activities”, мөн Canadian Oil and Gas Evaluation Handbook (COGEN) 2018 оны 9 дүгээр сард гэх зэргээр аргачлал, заавар, стандартууд бүхий баримт бичгүүддээ тогтмол нэмэлт өөрчлөлт хийн шинэчлэн хэрэглэсээр байна.

4. Монгол орны газрын тос ба хийн нөөцийн ангилал, зэрэглэлийг тогтоох, тооцоолох ба үнэлгээ өгөх үйл ажиллагааны нийтлэг горимыг зохицуулж, нүүрс-устөрөгчийн нөөц, баялгийн ашиглалт болон түүний сэргээгдэшгүй байдлаас үүсч болох хомсдолын эрин үед тэдгээрийг газрын хэвлийгээс аль болох бүрэн дүүрэн ашиглах эдийн засгийн болон арилжааны нөхцөлийг хангах, олон улсын хэмжээнд нийцэхүйц, хүлээн зөвшөөрөгдсөн, ашигт малтмалын судалгааны арга аргачлал, нөөцийн ангиллыг шинжлэх ухааны үндэслэлтэй, улмаар уламжлалт туршлага бүхий суурин дээрээ үндэслэн боловсронгуй болгох замаар цаашид дэлхийд өрсөлдөх чадварыг бий болгохуйц аргачилсан заавар шаардлагатай байх тул Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тосны эрэл, хайгуул хийж байгаа буюу эрлийн болон бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан байгууллагыг Монгол Улсын “Газрын тосны баялаг, ордын нөөцийн ангилал, зэрэглэлийг хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг мөрдөн ажиллах нь зүйтэй гэж үзэв.

*Аргачилсан зөвлөмж боловсруулагчийн илтгэл, тайлбар, шинжээчдийн дүгнэлт зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас гаргаж буй дараах зөвлөмжийг үндэслэн холбогдох шийдвэр гаргахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад уламжлахаар шийдвэрлэв.*

Нэг. Монгол Улсын “Газрын тосны баялаг, ордын нөөцийн ангилал, зэрэглэлийг хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг хүлээн авах.

Хоёр. Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т “Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага” батлах тухай болон Уул уурхайн сайдын 2015 оны 49 дүгээр тушаалаар “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайланд тавигдах шаардлага”-тай уялдуулан “Газрын тосны баялаг, ордын нөөцийн ангилал, зэрэглэлийг хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг хэрэгжүүлэх талаар холбогдох шийдвэр гаргах.

Гурав. Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлагын хүрээнд “Газрын тосны баялаг, ордын нөөцийн ангилал, зэрэглэлийг хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг хэрэглэх үндэслэлтэй болох тул Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тосны эрэл, хайгуул, ашиглалт хийж байгаа гэрээлэгч, тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд таниулан сурталчилахыг эрх бүхий байгууллагад чиглэл өгөх.

ТАНИЛЦСАН:

ЭБМЗ-ИЙН ДАРГА

Б.МОНХТӨР

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭБМЗ-ИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ  
ДАРГА

А.ДЭЛГЭРСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.БАЯРСАЙХАН



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН  
ЗӨВЛӨМЖ

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар ХХ-05-01

Улаанбаатар хот

“Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (төмөр) хэрэглэх аргачилсан зөвлөмж” хэлэлцсэн тухай

“Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (төмөр) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг Монгол Улсын зөвлөх инженер, геологич Ж.Цэнд-Аюуш, Монгол Улсын зөвлөх инженер, геологич, доктор /Ph.D/, профессор Г.Ухнаа, доктор /Ph.D/, дэд профессор П.Нарантуяа нар боловсруулж, зөвлөмжинд шинжээчээр Монгол Улсын зөвлөх геологич Б.Баасан, Монгол Улсын зөвлөх инженер, баяжуулагч, доктор /Ph.D/, дэд профессор Ц.Оюунцэцэг, Монгол Улсын зөвлөх инженер, баяжуулагч, доктор /Ph.D/, дэд профессор Н.Буянхишиг нар ажиллан дүгнэлт гаргасныг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд дараах **ЗӨВЛӨМЖ**-ийг гаргаж байна. Үүнд:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/46 тоот тушаалаар батлагдсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийн 4 дэх хэсэг буюу зөвлөлийн Салбар хуралдааны хэлэлцэх асуудлын 4.1.2.3-т “Ашигт малтмалын эрэл, хайгуулын ажлын арга, аргачлал, заавар, журмын төсөл болон ашигт малтмалын нөөцийн ангилал, түүнд тавигдах шаардлага, гарын авлага, зөвлөмж”-ийг хэлэлцэж зөвлөмж, дүгнэлт гаргах гэж заасны дагуу “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (төмөр) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаар хэлэлцсэн.

Аргачилсан зөвлөмж нь дараах үндсэн бүлгүүдээс бүрджээ. Үүнд:

- Ерөнхий ойлголтууд
- Хайгуулын зорилгоор ордыг геологийн тогтоцын нийлмэл байдлаар бүлэглэх нь
- Ордын геологийн тогтоц, хүдрийн эрдэслэг бүрэлдэхүүний судалгаа
- Хүдрийн технологийн шинж чанарын судалгаа
- Ордын гидрогеологи, инженер геологи, геоэкологийн ба байгалийн бусад нөхцлийн судалгаа
- Ордын нөөцийн тооцоолол ба баялгийн үнэлгээ
- Ордын судлагдсан байдал
- Ордын нөөцийг дахин тооцоолж баталгаажуулах

Мөн хавсралтаар төмрийн хүдрийн ангилал, зэрэглэл, төмрийн хүдрийг хайлуултад бэлтгэх ангилал, баяжмалын ерөнхий стандартын хүснэгтүүдийг оруулсан байна.

2. Аргачилсан зөвлөмж нь “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”, “Ашигт малтмалын тухай” хууль, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар

сарын 05-ны өдрийн А/20 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам”, Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалаар баталсан “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”-ын 3.7-д “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн зэрэглэл, ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалын онцлогт тулгуурлан гаргасан зааварт нийцүүлж болно” гэж тус тус заасантай нийцжээ.

3. Хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмалын баялаг, ордын нөөцийг нийтэд нээлттэй тайлагнах Монгол Улсын заавар (MRC Code) батлагдан, Ашигт малтмалын нөөцийг тайлагнах Олон Улсын стандартын хороо (CRIRSCO-Committee for Mineral Reserves International Reporting Standards)-нд 2014 онд гишүүнээр элсэж улмаар “Монгол Улсын хатуу ашигт малтмалын нөөц, эрдсийн баялгийн ангилал”-ыг Олон Улсын ижил төрлийн стандарт, заавруудтай дүйцүүлэх ажил хийгдсэнээр цаашид Монгол Улсад ашигт малтмалын хайгуулын ажлын аргачилсан зөвлөмж, нөөцийн ангиллын заавруудыг боловсруулах зайлшгүй шаардлага бий болсон.

Мөн олон улсын хэмжээнд тодорхой хатуу ашигт малтмалуудын нөөцийг тайлагнахад CRIRSCO-ийн зааварт нийцсэн Канад улс SIM “NI43-101”, Австрали улс “ЖОПК” гэх зэрэг заавар, стандартуудыг баримтлан зах зээл, томоохон хөрөнгийн биржүүдэд хувьцаа гаргаж, хөрөнгө босгох ажиллагаа амжилттай хэрэгжиж байна. Оросын Холбооны Улсад “Методические рекомендации по применению Классификации запасов месторождений и прогнозных ресурсов твердых полезных ископаемых” (2007) материалыг тухайн ашигт малтмалын төрөл тус бүрд тохируулан эрэл хайгуулын үйл ажиллагаандаа даган мөрдөн, хэрэгжүүлж байна.

Аргачилсан зөвлөмж нь олон улсын хэмжээнд мөрддөг Ашигт малтмалын нөөцийн ангилал, шаардлагуудтай нийцэж байгаа гэж зохиогч нар үзсэн байна. Ялангуяа ОХУ нь манай улстай хил залгаа оршдоогоороо ордуудын геологийн тогтоц нь адил төстэй, нөөцөөрөө дэлхийд дээгүүр багтдаг ба ордууд нь олон төрлийн нас, структурт үүссэн тул хайгуулын аргачлал, нөөцийн ангиллыг олон талаас нь нягталж хийгдсэнийг тооцоолон ОХУ-ын аргачилсан удирдамжийг түлхүү ашиглажээ. Ер нь Монголын геологичид ЗХУ-ын үеэс нөөцийн ангиллын зааврыг мөрдөж байсан тул ордын ихэнх нөөц энэ ангиллаар тогтоогдсоноос гадна Улсын геологийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа хайгуулын ажлын бараг бүх тайланд хэрэглэсэн нэр томъёо энэ зааврын дагуу хийгдсэн байдаг.

4. ЭБМЗ-ийн хуралдааны үед “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (төмөр) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-д тусгагдсан магнетитын хүдрийн 30% буюу түүнээс дээш хувь нь мартитэд хувирсан бол исэлдсэн хүдэрт оруулах шаардлагагүй болох, баяжуулах процесст мартин, домен зууханд тавигдах хүдрийн шаардлага болох 8-р хүснэгт байх шаардлагагүй, тухайн сонгосон технологийн схемийг аргачилсан зөвлөмжид тусгах шаардлагагүй гэж үзсэн бол уг зөвлөмжид жишиг үзүүлэлт, үйлдвэрлэлийн А<sup>1</sup>, В<sup>1</sup> нөөцийн тодорхойлолт, жишиг үзүүлэлтэд хүдрийн биетийн хамгийн бага зузаан байх, ордын судлагдсан байдал хэмээх 7-р бүлэг байх, өгөгдлийн сангийн тухай гэх зэргээр асуудлуудыг зөвлөлийн гишүүдийн олонхын саналыг үндэслэн аргачилсан зөвлөмжид тусгахаар шийдвэрлэсэн.

5. Зах зээлд уул уурхайн бүтээгдэхүүн болон хувьцаа гаргах, хөрөнгө босгох үйл ажиллагаа идэвхжсэн боловч Монгол Улсад тухайн ашигт малтмалын геологийн судалгаа, эрэл хайгуулын чиглэлээр мөрдөх журам, заавар, зөвлөмжгүй байгаатай уялдан Олон Улсын

хэмжээнд нийцэхүйц, хүлээн зөвшөөрөгдсөн, ашигт малтмалын судалгааны арга аргачлал, нөөцийн ангиллыг шинжлэх ухааны үндэслэлтэй, улмаар уламжлалт туршлага бүхий суурин дээрээ үндэслэн боловсронгуй болгох замаар цаашид дэлхийд өрсөлдөх чадварыг бий болгохуйц аргачилсан заавар шаардлагатай байх тул Монгол Улсын нутаг дэвсгэрт төмрийн ордын хайгуул хийж байгаа хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид, байгууллагуудыг “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (төмөр) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг мөрдөн ажиллах нь зүйтэй гэж үзэв.

*Аргачилсан зөвлөмж боловсруулагчийн илтгэл, тайлбар, шинжээчдийн дүгнэлт зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас гаргаж буй дараах зөвлөмжийг үндэслэн холбогдох шийдвэр гаргахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад уламжлахаар шийдвэрлэв.*

Нэг. “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (төмөр) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг хүлээн авах.

Хоёр. Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.17 дугаар заалтыг үндэслэн гарсан “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврын 3.7-д “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн зэрэглэл, ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалын онцлогт тулгуурлан гаргасан зааварт нийцүүлж болно” гэсний дагуу, “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилалыг тухайн төрлийн ашигт малтмалд (төмөр) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг хэрэгжүүлэх талаар холбогдох шийдвэр гаргах.

Гурав. “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааварт” суурилсан “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилалыг тухайн төрлийн ашигт малтмалд (төмөр) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг хэрэглэх үндэслэлтэй тул Монгол Улсын нутаг дэвсгэрт төмрийн ордын хайгуул хийж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчидэд таниулан сурталчилахыг эрх бүхий байгууллагад чиглэл өгөх.

ТАНИЛЦСАН:

ЭБМЗ-ИЙН ДАРГА

Б.МОНХТӨР

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:


ЭБМЗ-ИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ  
ДАРГА

А.ДЭЛГЭРСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.БАЯРСАЙХАН





УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН  
ЗӨВЛӨМЖ

2018 оны 04 сарын 05 өдөр

Дугаар ХХ-05-05

Улаанбаатар хот

“Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (хайлуур жонш) хэрэглэх аргачилсан зөвлөмж” хэлэлцсэн тухай

“Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (хайлуур жонш) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг Монгол Улсын зөвлөх геологич Ж.Банзрагч, Монгол Улсын зөвлөх геологич Д.Энхбаатар, доктор /Ph.D/ Б.Батхишиг нар боловсруулж, түүнд шинжээчээр Монгол Улсын мэргэшсэн геологич А.Дэлгэрсайхан, Монгол Улсын зөвлөх инженер, баяжуулагч, доктор /Ph.D/, дэд профессор Ц.Оюунцэцэг, Монгол Улсын зөвлөх инженер, баяжуулагч, доктор /Ph.D/, дэд профессор Н.Буянхишиг нар ажиллан дүгнэлт гаргасныг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд дараах **ЗӨВЛӨМЖ**-ийг гаргаж байна. Үүнд:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/46 тоот тушаалаар батлагдсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийн 4 дэх хэсэг буюу зөвлөлийн Салбар хуралдааны хэлэлцэх асуудлын 4.1.2.3-т “Ашигт малтмалын эрэл, хайгуулын ажлын арга, аргачлал, заавар, журмын төсөл болон ашигт малтмалын нөөцийн ангилал, түүнд тавигдах шаардлага, гарын авлага, зөвлөмж”-ийг хэлэлцэж зөвлөмж, дүгнэлт гаргах гэж заасны дагуу “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (хайлуур жонш) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаар хэлэлцсэн.

Аргачилсан зөвлөмж нь дараах үндсэн бүлгүүдээс бүрджээ. Үүнд:

- Ерөнхий ойлголтууд
- Хайгуулын зорилгоор ордын геологийн тогтоцын нийлмэл байдлаар бүлэглэх нь
- Ордын геологийн тогтоц, бодисын найрлагын судалгаа
- Хүдрийн технологийн шинж чанарын судалгаа
- Ордын гидрогеологи, инженер геологи, геоэкологийн ба байгалийн бусад нөхцлийн судалгаа
- Нөөцийн тооцоолол, баялгийн үнэлгээ
- Ордын судлагдсан байдал
- Нөөцийн дахин тооцоолол, баталгаажуулах

2. Аргачилсан зөвлөмж нь “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”, “Ашигт малтмалын тухай” хууль, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/20 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам”, Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалаар баталсан “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”-ын 3.7-д “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн зэрэглэл, ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалын онцлогт тулгуурлан гаргасан зааварт нийцүүлж болно” гэж тус тус заасантай нийцжээ.

3. Хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмалын баялаг, ордын нөөцийг нийтэд нээлттэй тайлагнах Монгол Улсын заавар (MRC Code) батлагдан, Ашигт малтмалын нөөцийг тайлагнах Олон Улсын стандартын хороо (CRIRSCO-Committee for Mineral Reserves International Reporting Standards)-нд 2014 онд гишүүнээр элсэж улмаар “Монгол Улсын хатуу ашигт малтмалын нөөц, эрдсийн баялгийн ангилал”-ыг Олон Улсын ижил төрлийн стандарт, заавруудтай дүйцүүлэх ажил хийгдсэнээр цаашид Монгол Улсад ашигт малтмалын хайгуулын ажлын аргачилсан зөвлөмж, нөөцийн ангиллын заавруудыг боловсруулах зайлшгүй шаардлага бий болсон байна.

Мөн олон улсын хэмжээнд тодорхой хатуу ашигт малтмалуудын нөөцийг тайлагнахад CRIRSCO-ийн зааварт нийцсэн Канад улс SIM “NI43-101”, Австрали улс “ЖОПК” гэх зэрэг заавар, стандартуудыг баримтлан зах зээл, томоохон хөрөнгийн биржүүдэд хувьцаа гаргаж, хөрөнгө босгох ажиллагаа амжилттай хэрэгжиж байна. Оросын Холбооны Улсад “Методические рекомендации по применению Классификации запасов месторождений и прогнозных ресурсов твердых полезных ископаемых” (2007) материалыг тухайн ашигт малтмалын төрөл тус бүрд тохируулан эрэл хайгуулын үйл ажиллагаандаа даган мөрдөн, хэрэгжүүлж байна.

Аргачилсан зөвлөмж нь олон улсын хэмжээнд мөрддөг Ашигт малтмалын нөөцийн ангилал, шаардлагуудтай нийцэж байгаа гэж зохиогч нар үзсэн байна. Ялангуяа ОХУ нь манай улстай хил залгаа оршдоогоороо ордуудын геологийн тогтоц нь адил төстэй, нөөцөөрөө дэлхийд дээгүүр багтдаг ба ордууд нь олон төрлийн нас, структурт үүссэн тул хайгуулын аргачлал, нөөцийн ангиллыг олон талаас нь нягталж хийгдсэнийг тооцоолон ОХУ-ын аргачилсан удирдамжийг түлхүү ашиглажээ. Ер нь Монголын геологичид ЗХУ-ын үеэс нөөцийн ангиллын зааврыг мөрдөж байсан тул ордын ихэнх нөөц энэ ангиллаар тогтоогдсоноос гадна Улсын геологийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа хайгуулын ажлын бараг бүх тайланд хэрэглэсэн нэр томьёо энэ зааврын дагуу хийгдсэн байдаг.

4. ЭБМЗ-ийн хуралдааны үед “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (хайлуур жонш) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-д карбонатиттай холбоотой ордын төрлийг нэмэх, 2016 онд батлагдсан хайлуур жоншны Монгол Улсын стандартуудыг оруулах, ашигласан хэвлэлд нэмэх, вулкан плутон, U, Pb-Zn холбоотой ордуудыг нэмэх, зарим ижил нэр томьёог бусад аргачилсан зөвлөмжид өөр өөрөөр тусгагдсан байгааг анхаарч нэг мөр болгох зэрэг асуудлуудыг зөвлөлийн гишүүдийн олонхын саналыг үндэслэн аргачилсан зөвлөмжид тусгахаар шийдвэрлэсэн.

5. Зах зээлд уул уурхайн бүтээгдэхүүн болон хувьцаа гаргах, хөрөнгө босгох үйл ажиллагаа идэвхжсэн боловч Монгол Улсад тухайн ашигт малтмалын геологийн судалгаа, эрэл хайгуулын чиглэлээр мөрдөх журам, заавар, зөвлөмжгүй байгаатай уялдан Олон Улсын хэмжээнд нийцэхүйц, хүлээн зөвшөөрөгдсөн, ашигт малтмалын судалгааны арга аргачлал, нөөцийн ангиллыг шинжлэх ухааны үндэслэлтэй, улмаар уламжлалт туршлага бүхий суурин дээрээ үндэслэн боловсронгуй болгох замаар цаашид дэлхийд өрсөлдөх чадварыг бий болгохуйц аргачилсан заавар шаардлагатай байх тул Монгол Улсын нутаг дэвсгэрт хайлуур жоншны ордын хайгуул хийж байгаа хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид, байгууллагуудыг “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилалыг тухайн төрлийн ашигт малтмалд (хайлуур жонш) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг мөрдөн ажиллах нь зүйтэй гэж үзэв.

Цаашид “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (хайлуур жонш) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг тухай бүр сайжруулан засварлаж дагаж мөрдөх шаардлагатай болохыг тэмдэглэв.



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН  
ЗӨВЛӨМЖ

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар ХХ-05-0Э

Улаанбаатар хот

“Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилалыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж (Шороон орд)” хэлэлцсэн тухай

“Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилалыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж (Шороон орд)”-ийг Монгол Улсын зөвлөх инженер, геологич, доктор /Ph.D/ Г.Жамсрандорж, Монгол Улсын зөвлөх инженер, геологич С.Цэрэн-Очир, Монголын Улсын мэргэшсэн геологич, доктор /Ph.D/ Б.Алтанзул, түүнд шинжээчээр томилогдсон Монгол Улсын зөвлөх геологич Б.Алтан-Очир, Монгол Улсын зөвлөх инженер, баяжуулагч, доктор /Ph.D/, дэд профессор Ц.Оюунцэцэг, Монгол Улсын зөвлөх инженер, баяжуулагч, доктор /Ph.D/, дэд профессор Н.Буянхишиг нарын дүгнэлтийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд дараах ЗӨВЛӨМЖ-ийг гаргаж байна. Үүнд:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/46 тоот тушаалаар батлагдсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийн 4 дэх хэсэг буюу зөвлөлийн Салбар хуралдааны хэлэлцэх асуудлын 4.1.2.3-т “Ашигт малтмалын эрэл, хайгуулын ажлын арга, аргачлал, заавар, журмын төсөл болон ашигт малтмалын нөөцийн ангилал, түүнд тавигдах шаардлага, гарын авлага, зөвлөмж”-ийг хэлэлцэж зөвлөмж, дүгнэлт гаргах гэж заасны дагуу “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилалыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж (Шороон орд)”-ийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаар хэлэлцсэн бөгөөд аргачилсан зөвлөмж нь дараах үндсэн бүлгүүдээс бүрджээ. Үүнд:

- Ерөнхий ойлголтууд
- Ашигт малтмалын шороон ордын онцлог
- Шороон ордыг нийлмэл байдлаар бүлэглэх нь
- Шороон ордын геологийн тогтоц, бодисын найрлагын судалгаа
- Элсний технологийн шинж чанарын судалгаа
- Ордын гидрогеологи, инженер-геологи, уул-геологийн болон бусад байгалийн нөхцөлийн судалгаа
- Нөөцийн тооцоолол
- Ордын, түүний хэсгүүдийн судлагдсан байдал
- Ордын нөөцийн дахин тооцоолол ба бүртгэлжүүлэлт

Мөн хавсралтаар ашигласан материал, бусад хавсралтуудыг оруулсан байна.

2. Аргачилсан зөвлөмж нь “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”, “Ашигт малтмалын тухай” хууль, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/20 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам”, Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн



203 дугаар тушаалаар баталсан “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”-ын 3.7-д “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн зэрэглэл, ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалын онцлогт тулгуурлан гаргасан зааварт нийцүүлж болно” гэж тус тус заасантай нийцжээ.

3. Хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмалын баялаг, ордын нөөцийг нийтэд нээлттэй тайлагнах Монгол Улсын заавар (MRC Code) батлагдан, Ашигт малтмалын нөөцийг тайлагнах Олон Улсын стандартын хороо (CRIRSCO-Committee for Mineral Reserves International Reporting Standards)-нд 2014 онд гишүүнээр элсэж улмаар “Монгол Улсын хатуу ашигт малтмалын нөөц, эрдсийн баялгийн ангилал”-ыг Олон Улсын ижил төрлийн стандарт, заавруудтай дүйцүүлэх ажил хийгдсэнээр цаашид Монгол Улсад ашигт малтмалын хайгуулын ажлын аргачилсан зөвлөмж, нөөцийн ангиллын заавруудыг боловсруулах зайлшгүй шаардлага бий болсон байна.

Мөн олон улсын хэмжээнд тодорхой хатуу ашигт малтмалуудын нөөцийг тайлагнахад CRIRSCO-ийн зааварт нийцсэн Канад Улс SIM “NI43-101”, Австрали Улс “ЖОРК” гэх зэрэг заавар, стандартуудыг баримтлан зах зээл, томоохон хөрөнгийн биржүүдэд хувьцаа гаргаж, хөрөнгө босгох ажиллагаа амжилттай хэрэгжиж байна. Оросын Холбооны Улсад “Методические рекомендации по применению Классификации запасов месторождений и прогнозных ресурсов твердых полезных ископаемых” (Россыпные месторождения, 2007) материалыг тухайн ашигт малтмалын төрөл тус бүрд тохируулан эрэл хайгуулын үйл ажиллагаандаа даган мөрдөн, хэрэгжүүлж байна.

Аргачилсан зөвлөмж нь Олон Улсын хэмжээнд мөрддөг Ашигт малтмалын нөөцийн ангилал, шаардлагуудтай нийцэж байгаа гэж зохиогч нар үзсэн байна. Ялангуяа ОХУ нь манай улстай хил залгаа оршдоогоороо, Сибирийн өмнөд нутгийн ялангуяа алтны шороон ордуудын геологийн тогтоц нь адил төстэй, нөөцөөрөө дэлхийд дээгүүр багтдаг ба ордууд нь олон төрлийн нас, структурт үүссэн тул хайгуулын аргачлал, нөөцийн ангиллыг олон талаас нь нягталж хийгдсэнийг тооцоолон ОХУ-ын аргачилсан удирдамжийг түлхүү ашиглажээ. Ер нь Монголын геологчид 1990 оноос өмнө ЗХУ-ын үеэс нөөцийн ангиллын зааврыг мөрдөж байсан тул ордын ихэнх нөөц энэ ангиллаар тогтоогдсоноос гадна Улсын геологийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа хайгуулын ажлын бараг бүх тайланд хэрэглэсэн нэр томьёо энэ зааврын дагуу хийгдсэн байдаг.

4. ЭБМЗ-ийн хуралдааны үед зөвлөлийн гишүүдийн олонхын саналыг үндэслэн “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилалыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж (Шороон орд)”-д тусгагдсан ховор шороон элемент гэснийг газрын ховор шороон элемент, Заамарын хүдрийн зангилаа гэснийг Заамарын хүдрийн дүүрэг гэж тус тус засах, 4.5 дахь хэсгийг Ашигласан материалын жагсаалтад оруулах, гидрогеологийн бүлэгт холбогдох засварыг хийж аргачилсан зөвлөмжид тусгахаар шийдвэрлэсэн.

5. Зах зээлд уул уурхайн бүтээгдэхүүн болон хувьцаа гаргах, хөрөнгө босгох үйл ажиллагаа идэвхжсэн боловч Монгол Улсад тухайн ашигт малтмалын геологийн судалгаа, эрэл хайгуулын чиглэлээр мөрдөх журам, заавар, зөвлөмжгүй байгаатай уялдан Олон Улсын хэмжээнд нийцэхүйц, хүлээн зөвшөөрөгдсөн, ашигт малтмалын судалгааны арга аргачлал, нөөцийн ангиллыг шинжлэх ухааны үндэслэлтэй, улмаар уламжлалт туршлага бүхий суурин дээрээ үндэслэн боловсронгуй болгох замаар цаашид дэлхийд өрсөлдөх чадварыг бий болгохуйц аргачилсан заавар шаардлагатай байх тул Монгол Улсын нутаг дэвсгэрт шороон ордын хайгуул хийж байгаа хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид, байгууллагыг “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилалыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж (Шороон орд)”-ийг ашиглахыг мөрдөн ажиллах нь зүйтэй гэж үзэв.

Цаашид “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилалыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж (Шороон орд)”-ийг тухай бүр сайжруулан засварлаж дагаж мөрдөх шаардлагатай болохыг тэмдэглэв.

*Аргачилсан зөвлөмж боловсруулагчийн илтгэл, тайлбар, шинжээчдийн дүгнэлт зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас гаргаж буй дараах зөвлөмжийг үндэслэн холбогдох шийдвэр гаргахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад уламжлахаар шийдвэрлэв.*

Нэг. “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилалыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж (Шороон орд)”-ийг хүлээн авах.

Хоёр. Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.17 дугаар заалтыг үндэслэн гарсан “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврын 3.7-д “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн зэрэглэл, ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалын онцлогт тулгуурлан гаргасан зааварт нийцүүлж болно” гэсний дагуу, “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилалыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж (Шороон орд)”-ийг хэрэгжүүлэх талаар холбогдох шийдвэр гаргах,

Гурав. “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааварт” суурилсан “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилалыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж (Шороон орд)”-ийг хэрэглэх үндэслэлтэй болох тул Монгол Улсын нутаг дэвсгэрт шороон ордын хайгуул хийж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчидэд таниулан сурталчилахыг эрх бүхий байгууллагад чиглэл өгөх.

ТАНИЛЦСАН:

ЭБМЗ-ИЙН ДАРГА

Б.МӨНХТӨР

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭБМЗ-ИЙН САЛБАР ХУРАЛДААНЫ  
ДАРГА

А.ДЭЛГЭРСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Б.БАЯРСАЙХАН



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН  
ЗӨВЛӨМЖ

2019 оны 07 сарын 24 өдөр

Дугаар ХХ-14-01

Улаанбаатар хот

“Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (Зэс) хэрэглэх аргачилсан зөвлөмж” хэлэлцсэн тухай

“Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (Зэс) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг Монгол Улсын зөвлөх геологич, доктор /Ph.D./ С.Жаргалан, Монгол Улсын мэргэшсэн геологич Г.Алтанхуяг, Б.Мөнхбат, доктор /Ph.D./, Б.Энхжаргал, Монгол Улсын зөвлөх геологич С.Мөнхбадрах, Олон улсын итгэмжлэгдсэн геологич Т.Отгонбаяр нар боловсруулж, зөвлөмжинд шинжээчээр Монгол Улсын зөвлөх инженер, доктор /Ph.D./ Л.Түдэв, Монгол Улсын мэргэшсэн геологич Ж.Сүх-Очир, М.Дамдинсүрэн нар ажиллан дүгнэлт гаргасныг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд дараах **ЗӨВЛӨМЖ**-ийг гаргаж байна. Үүнд:

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/46 тоот тушаалаар батлагдсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийн 4 дэх хэсэг буюу зөвлөлийн Салбар хуралдааны хэлэлцэх асуудлын 4.1.2.3-т “Ашигт малтмалын эрэл, хайгуулын ажлын арга, аргачлал, заавар, журмын төсөл болон ашигт малтмалын нөөцийн ангилал, түүнд тавигдах шаардлага, гарын авлага, зөвлөмж”-ийг хэлэлцэж зөвлөмж, дүгнэлт гаргах гэж заасны дагуу “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (зэс) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаар хэлэлцсэн.

Аргачилсан зөвлөмж нь дараах үндсэн бүлгүүдээс бүрджээ. Үүнд:

- Ерөнхий ойлголт
- Хайгуулын зорилгоор ордуудын геологийн тогтоцын нийлмэл байдлаар бүлэглэх нь
- Ордын геологийн тогтоцын ба хүдрийн бодисын найрлагын судалгаа
- Хүдрийн технологийн шинж чанарын судалгаа
- Ордын гидрогеологи, инженер геологи, геоэкологийн ба байгалийн бусад нөхцлийн судалгаа
- Нөөцийн тооцоо
- Ордын (түүний хэсгүүдийн) судалгааны түвшин
- Нөөцийг дахин тооцоолол ба дахин бүртгэлт

Мөн хавсралтаар хатуу ашигт малтмалын ордуудыг геологийн тогтоцын нийлмэл байдлын тогтооход ашигладаг үзүүлэлтүүд, зарим нэр томъёоны тайлбарыг оруулсан байна.

2. Аргачилсан зөвлөмж нь “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”, “Ашигт малтмалын тухай” хууль, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/20 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааны журам”, Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалаар баталсан “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”-

ын 3.7-д “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн зэрэглэл, ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалын онцлогт тулгуурлан гаргасан зааварт нийцүүлж болно” гэж тус тус заасантай нийцжээ.

3. Хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмалын баялаг, ордын нөөцийг нийтэд нээлттэй тайлагнах Монгол Улсын заавар (MRC Code) батлагдан, Ашигт малтмалын нөөцийг тайлагнах Олон Улсын стандартын хороо (CRIRSCO-Committee for Mineral Reserves International Reporting Standards)-нд 2014 онд гишүүнээр элсэж улмаар “Монгол Улсын хатуу ашигт малтмалын нөөц, эрдсийн баялгийн ангилал”-ыг Олон Улсын ижил төрлийн стандарт, заавруудтай дүйцүүлэх ажил хийгдсэнээр цаашид Монгол Улсад ашигт малтмалын хайгуулын ажлын аргачилсан зөвлөмж, нөөцийн ангиллын заавруудыг боловсруулах зайлшгүй шаардлага бий болсон.

Мөн олон улсын хэмжээнд тодорхой хатуу ашигт малтмалуудын нөөцийг тайлагнахад CRIRSCO-ийн зааварт нийцсэн Канад улс SIM “NI43-101”, Австрали улс “ЖОРК” гэх зэрэг заавар, стандартуудыг баримтлан зах зээл, томоохон хөрөнгийн биржүүдэд хувьцаа гаргаж, хөрөнгө босгох ажиллагаа амжилттай хэрэгжиж байна. Оросын холбооны улсад “Методические рекомендации по применению Классификации запасов месторождений и прогнозных ресурсов твердых полезных ископаемых” (Медные руды, 2007) материалыг тухайн ашигт малтмалын төрөл тус бүрд тохируулан эрэл хайгуулын үйл ажиллагаандаа даган мөрдөн, хэрэгжүүлж байна.

Аргачилсан зөвлөмж нь олон улсын хэмжээнд мөрддөг Ашигт малтмалын нөөцийн ангилал, шаардлагуудтай нийцэж байгаа гэж зохиогч нар үзсэн байна. Ялангуяа манай улсад зэсийн Эрдэнэт, Цагаансуварга зэрэг олон арван орд, илрэлүүдийн эрэл, хайгуул хийж, хил залгаа газар нутагт нээгдсэн ордуудын геологийн тогтоц нь адил төстэй, нөөцөөрөө дэлхийд дээгүүр багтдаг ба ордууд нь олон төрлийн нас, структурт үүссэн тул хайгуулын аргачлал, нөөцийн ангиллыг олон талаас нь нягталж хийгдсэнийг тооцоолон ОХУ-ын аргачилсан удирдамжийг түлхүү, мөн барууны аргачлал, туршлагаар сүүлийн жилүүдэд Оюу толгой зэрэг орд, илрэлд явуулсан геологичдын туршлагад тулгуурлан зөвлөмжийг боловсруулжээ. Монголын геологичид ЗХУ-ын үеэс нөөцийн ангиллын зааврыг мөрдөж байсан тул ордын ихэнх ордуудын нөөц энэ ангиллаар тогтоогдсоноос гадна Улсын геологийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа хайгуулын ажлын бараг бүх тайланд хэрэглэсэн нэр томъёо энэ зааврын дагуу хийгдсэн байдаг.

4. ЭБМЗ-ийн хуралдааны үед “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (зэс) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийн зарим нэр томъёог дахин нягтлах, дээжийн хадгалалтын талаар нэмж оруулах зэрэг асуудлуудыг зөвлөлийн гишүүдийн олонхын саналыг үндэслэн аргачилсан зөвлөмжид нэмж тусгахаар шийдвэрлэсэн.

5. Зах зээлд уул уурхайн бүтээгдэхүүн болон хувьцаа гаргах, хөрөнгө босгох үйл ажиллагаа идэвхжсэн боловч Монгол Улсад зэсийн хүдрийн ордын геологийн судалгаа, эрэл хайгуулын чиглэлээр мөрдөх журам, заавар, зөвлөмжгүй байгаатай уялдан Олон Улсын хэмжээнд нийцэхүйц, хүлээн зөвшөөрөгдсөн, ашигт малтмалын судалгааны арга аргачлал, нөөцийн ангиллыг шинжлэх ухааны үндэслэлтэй, улмаар уламжлалт туршлага бүхий суурин дээрээ үндэслэн боловсронгуй болгох замаар цаашид дэлхийд өрсөлдөх чадварыг бий болгохуйц аргачилсан заавар шаардлагатай байх тул Монгол Улсын нутаг дэвсгэрт зэсийн ордын хайгуул хийж байгаа хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид, байгууллагуудыг “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (зэс) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг мөрдөн ажиллах нь зүйтэй гэж үзэв.

Аргачилсан зөвлөмж боловсруулагчийн илтгэл, тайлбар, шинжээчдийн дүгнэлт зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас гаргаж буй дараах зөвлөмжийг үндэслэн холбогдох шийдвэр гаргахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад уламжлахаар шийдвэрлэв.


Нэг. “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд (зэс) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг хүлээн авах.

Хоёр. Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.17 дугаар заалтыг үндэслэн гарсан “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааврын 3.7-д “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн зэрэглэл, ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалын онцлогт тулгуурлан гаргасан зааварт нийцүүлж болно” гэсний дагуу, “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилалыг тухайн төрлийн ашигт малтмалд (зэс) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг хэрэгжүүлэх талаар холбогдох шийдвэр гаргах.

Гурав. “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, зааварт” суурилсан “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилалыг тухайн төрлийн ашигт малтмалд (зэс) хэрэглэх аргачилсан зөвлөмж”-ийг хэрэглэх үндэслэлтэй тул Монгол Улсын нутаг дэвсгэрт зэсийн ордын хайгуул хийж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчидэд таниулан сурталчилахыг эрх бүхий байгууллагад чиглэл өгөх.

ТАНИЛЦСАН:

ЭБМЗ-ИЙН ДАРГА



Б.МӨНХТӨР

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:


ЭБМЗ-ИЙН САЛБАР ХУРАЛДААНЫГ  
ДАРГА



А.ДЭЛГЭРСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Б.БАЯРСАЙХАН